

2021-2022 ОНЫ СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙГДЛЭЭ 2022.08.26 МУ-ын Засгийн газар, Дэлхийн банк хооронд хийсэн хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлж буй "Тогтвортой амжиргаа-3" төслийн хүрээнд 2021, 2022 оны ОНХС-ийн үйл ажиллагааны жилийн гүйцэтгэлд үнэлгээ хийгдлээ. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ нь Олон нийтийн оролцоо, төлөвлөлт, ил тод байдал, гүйцэтгэл, хяналт шинжилгээ үнэлгээ, өмчийн удирдлагын хүрээнд нийт 34 үзүүлэлтээр дүгнэгдэх юм. Тус үнэлгээгээр 2023 онд сумын орон нутгийн хөгжлийн санд урамшуулал олгох эсэх нь шийдвэрлэгдэх юм. 1. ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдал 2. Малын тоо толгойн албан татварын хэмжээг малчдад хэрхэн мэдээлсэн, уг татварын орлогыг 2021-2022 онд ямар зардалд зарцуулахаар шийдвэрлэсэн эсэх 3. Татварын орлогыг бүрдүүлэхэд хүндрэл бэрхшээл байгаа эсэх 4. Сумын удирдлага, байгаль орчин, нийгмийг хамгаалах талаар ямар төрлийн дэмжлэг, чиглэл зөвлөмж, сургалтад хамрагдсан эсэх 5. ОНХС-аас санхүүжүүлэх төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд эдгээр дэмжлэг, сургалтыг хэрхэн ашигласан талаар тодруулах зорилготой бүлгийн ярилцлагыг сумын Засаг даргын орлогч, холбогдох албаны мэргэжилтэн, иргэний төлөөллийг оролцуулан бүлгийн ярилцлага хийж тодруулсан юм.



